

Хүн ам зүйн мэдээллийн өнөөгийн тогтолцоог сайжруулах арга зам , хүн амын автоматжуулсан төв регистрийг хөгжүүлэх арга

Ц.Цэдэв

**Иргэний Бүртгэл, Мэдээллийн
Улсын Төвийн хэлтсийн дарга**

Нийгэм эдийн засгийн макро удирдлагыг боловсронгуй болгоход түүний мэдээллийн системийг сайжруулах явдал чухал үүрэгтэй. Нөгөө талаар зах зээлийн харилцаанд орж байгаа өнөөгийн нөхцөлд манай орны эдийн засгийн мэдээллийн системийг олон улсынхад ойртуулах, ижилсгэх явдал чухлаар тавигдаж байна. Улс орны хөгжилд нөлөөлөх нэг чухал хүчин зүйл нь хүн хүч, нөгөө нь менежмент байх нь тодорхой. Дээрх асуудалд эдийн засгийн, тэр дотроо хүн ам зүйн мэдээлэл чухал ач холбогдолтой юм.

Сүүлийн жилүүдэд дэлхийн олон улсын дээд хэмжээний уулзалтаас гаргасан баримт бичигт хүн амын бүртгэлийн үзүүлэлтийг тодорхойлох, мэдээг цуглуулах, шинжлэн дүгнэх, хэрэглэгчдэд хүргэх, хэрэгцээг хангах, ялангуяа хүн амын нас, хүйс, омгийн байдал, газар зүйн байршлын талаархи мэдээг онцлон анхаарах, үүний үндсэн дээр хүн ам ба нийгэм-эдийн засаг, түүний дотор хүрээлэн байгаа орчны өөрчлөлтүүдийн хоорондын холбоог ойлгох, урьдчилан харах, энэ талын бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэлтийг сайжруулахад шаардлагатай тоо материалын баазыг буй болгох, үндэсний мэдээллийн сан байгуулах зорилгыг дэвшүүлсээр байна. Түүнчлэн улс орны хөгжлийн түвшинг хүний хөгжлийн индексээр тооцох хандлагатай болов.

XX зууны дунд үеэс эхлэн дэлхийн хөгжингүй орнууд хүн амын регистрийн системийг байгуулан хөгжүүлэх замаар хүн амын мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгон хүн амын мэдээллийн сүлжээг улсынхаа хэмжээнд байгуулан ашиглаж, засаг захиргааны аль ч түвшинд хүн амын холбогдолтой мэдээллээр өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээгээ хангаж эхлэв. Хүн амын регистрийн системийг түлхүү хөгжүүлсэн улс орнууд өнөөдөр хүн амын тооллогыг явуулах шаардлагагүй болж хүн амын тооллоготой дүйцэхүйц тоо материалыг регистрийн системээс гарган ашиглаж байна.

Манай улсын хүн ам зүйн мэдээллийн өнөөгийн тогтолцоо, гаргаж байгаа үзүүлэлт, материал нь зах зээлийн эдийн засгийн харилцааны шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал нэг талаас улсын статистикийн газраас гаргаж байгаа мэдээ тайланд хүн амын байршил, нас хүйс, төрөлт, нас баралтын үзүүлэлтийн хэмжээ, чанар, мэдээ тайлангийн үнэн зөв шуурхай байдал дутагдалтай. Шилжих хөдөлгөөн ялангуяа аймаг нийслэл хооронд шилжиж байгаа иргэдийн талаархи мэдээ материал үндэслэл муутай, хамгийн хүрэлцээгүй, нөгөө талаас хүн амын мэдээллийг олон байгууллага хариуцан мэдээ тайлангын давхардалт байсаар байгаа нь энэ талаархи асуудал шийдвэрлэхэд түвэг учруулж байна. Гэвч манай улсын хүн ам цөөхөн, иргэний гэр бүлийн байдлын бүртгэл 1951, шилжих хөдөлгөөний бүртгэлийг 1960 оноос эхлэн хөтлөж хэвшсэн нөгөө талаас

тооцоолох техник хэрэгсэл нэвтэрч мэргэжлийн боловсон хүчин зохих хэмжээгээр бэлтгэгдсэн манай орны хувьд дэлхийн орнуудын нэгэн адил хүн амын мэдээллийн дэвшилтэт эх үүсвэр болох иргэний бүртгэл мэдээллийн автоматжуулсан системийг байгуулах замаар дээрх бэрхшээлээс гарах нөхцөл бололцоог бүрдүүлж байна. Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлогын 6-р бүлгийн 32-т "Иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сүлжээ бүрдүүлж, үйл ажиллагааг тогтвортой хангах бодлого баримтална" гэж заасан нь чухамхүү зах зээлийн харилцаанд орж байгаа манай орны хувьд хүн ам зүйн мэдээллийн үнэн зөв, шуурхай байдал, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ шаардлагыг хангахад чухал үр нөлөөтэй юм.

Нэг. Монгол улсын хүн амын автоматжуулсан төв регистрийн тухай

1978–1988 онд Монгол улсын нийт хүн ам буюу бараг 2 сая шахам иргэдэд регистрийн дугаар олгож, хүн нэг бүрийн мэдээллийг "регистрийн карт" маягтаар цуглуулж авсан. Эдгээр картын үзүүлэлтийг компьютерт оруулахад гурван байгууллагыг дамжуулан, нийтдээ 6 жил зарцуулж, 1993 оны эцсээр дуусгасан. Холбогдох программ хангамжийг бичин 1994 оноос хүн амын автоматжуулсан төв регистрийн мэдээллийн сангаас иргэний холбогдолтой лавлагааг гаргадаг болж ард иргэд, албан байгууллагад үйлчилж эхэлсэн юм. Энэ хугацаанд мэдээллийн санг баяжуулах төрөлт, нас баралт, гэрлэлт, гэр бүл цуцлалт гэх мэт хүн амын ердийн хөдөлгөөн түүнчлэн шилжих хөдөлгөөн иргэний паспорт авсны 2,4 сая материал хуримтлагдсаныг нөхөн оруулснаар одоо ИБМУТ 1988–1995 оныг дуусган 1996 оны эхний хагас жилийн мэдээллийг оруулааад байна. 1997 оны эхний хасагт хүлээгдэж хуримтлагдсан бүх мэдээллийг компьютерт оруулж дуусган цаашид ирсэн мэдээллийг тухай бүр компьютерт оруулах юм.

Засгийн газрын 1994 оны 94-р тогтоолоор ИБМУТ хүн амын шилжих хөдөлгөөний тайланг 1997 оноос эхлэн гаргаж Улсын статистикийн газар мэдээлж байгаа бөгөөд цаашид хагас жил, жилээр байнга мэдээлж байх юм. Түүнчлэн 1997 оны эхний хагасаас хүн амын ердийн хөдөлгөөн, тухайлбал төрөлт, нас баралт, гэрлэлт, гэр бүл цуцлалтын мэдээ тайланг гаргаж холбогдох газруудад тогтмол мэдээлдэг болох юм. Статистикийн улсын тайлангаар гардаггүй, шаардлагтай бол улсаас ихээхэн хөрөнгө, хүч зарцуулж байж гаргах хүн амын хэтийн тооцоо, хүний хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон олон чухал судалгаа шинжилгээний тоо материалыг ХААТР-ын мэдээллийн сангаас гаргах боломжтой байна.

ХААТР-ын сангийн мэдээллийг чанаржуулах, сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх олон арга зам байна. Тухайлбал бүх шатны байгууллагуудаас тэдгээрт ажиллаж байгаа хүмүүсийн жагсаалтыг гаргуулан авч, цаашид ажил өөрчлөлтийн мэдээллийг тогтмол авч чадвал хөдөлмөр эрхлэлтийн, бүх шатны сургууль төгсөгчид, эзэмшсэн боловсрол, мэргэжлийн жагсаалтыг жил бүр байнга авч чадвал Монгол улсын нийт хүн амын боловсрол, мэргэжлийн байдлыг ХААТР-ын мэдээллийн сангаас гаргах боломжтой. Одоогоор манай улсад татвар, эрүүл мэндийн даатгалын ажилд регистрийн дугаарыг ашиглаж байна.

Манай орон регистрийн системийг түлхүү хөгжүүлэхэд анхаарч чадвал 10 жил тутам явуулдаг хүн амын тооллогын материалыг регистрийн мэдээллийн сангаас жил бүр байнга гаргах боломжтой.

Хоёр. Хүн амын мэдээллийн тогтолцоог сайжруулах асуудал

СНЗ-ийн (хуучин нэрээр) 1984 оны 274-р тогтоолоор хүн амын холбогдолтой тоо материалыг гаргах ажлыг боловсронгуй болгох, сайжруулах зорилгоор Монгол улсын хүн амын автоматжуулсан төв регистрийг байгуулах, Монгол улсын харьяат иргэдэд регистрийн дугаар олгох заасан нь хүн амын бүртгэл, мэдээллийн тогтолцоог өөрчилж, боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой болсон юм. Тэр үеийн хүн ам зүйн тогтолцоог зураг N1 –ээр үзүүлэв.

СНЗ-ийн (хуучин нэрээр) 1987 оны 122-р тогтоолоор Шүүх яамны Иргэний гэр бүлийн бүртгэлийн төв архив, ЦЕГ-ын хаягийн санг нэгтгэн Иргэний баримт бичгийн төв архивыг байгуулж, ЦЕГ-т харьяалуулснаар мэдээллийн шат дамжлагыг цөөлж, мэдээний давхардлыг багасган хөрөнгө, хүч хөдөлмөр хэмнэсэн, иргэдийн чирэгдлийг багасган лавлагааг төвлөрсөн нэг газраас олгодог болж, тухайн үеийн хүн амын тогтолцоонд шинэ өөрчлөлтийг оруулсан юм. Энэ тогтолцоо өнөөг хүртэл хэвээр хадгалагдаж байна.

Иргэний гэр бүлийн бүртгэлийн ажлыг сумын түвшинд өөр өөр албан тушаалтан хариуцаж байгаа нь мэдээ тайлангын чанарт муугаар нөлөөлж байна. Иргэний гэр бүлийн бүртгэлийг хөтлөх бүрт улсын төсвөөс мөнгө авах эрх олгогддог. Тухайлбал тэжээгчээ алдсаны тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн тэтгэвэр, эрүүл мэндийн даатгал, их дээд сургуульд үнэгүй суралцах гэх мэт... Иймээс энэ бүртгэлийн ажлыг Сумын Засаг даргын тамгын газрын орлогч даргад хариуцуулах саналыг засгийн газарт шийдвэрлүүлэхээр оруулаад байна.

Аймгийн хэмжээнд иргэний гэр бүлийн байдлыг бүртгэлийг хариуцсан мэргэжлийн удирдлагаар ханган ажилладаг ажилтныг аймгийн Засаг даргын тамгын газарт хариуцуулахаар өөрчлөлт хийж байна. Ер нь Монгол улсад иргэний бүртгэл мэдээллийн хуультай болох шаардлагатай байгаа бөгөөд энэ талаар тодорхой ажлуудыг ИБМУТ хариуцан хийж байна.

Өнөөдрийн хүн амын мэдээллийн тогтолцоог үзэхэд мэдээ тайлангын давхардал байсаар байгааг цаашид өөрчлөн зохион байгуулах шаардлагатай байна. Улсын их хурлын 1996 оны 40 дугаар тогтоолоор ИБМУТ-ийг хэрэгжүүлэгч агентлаг болгосон нь чухал ач холбогдолтой болов. Энэ нь Монгол улсад хүн амын холбогдолтой мэдээ тайланг гаргаж мэдээлэх ажилд зохих нөлөө үзүүлж, өөрчлөлт хийхэд тааламжтай нөхцлийг бүрдүүлж байна.

Гурав. Хүн амын автоматжуулсан төв регистрийг хөгжүүлэх асуудал

Хүн амын автоматжуулсан төв регистрийн мэдээллийн санг ажил төрлийн холбоотой олон байгууллагууд ашиглах хүсэлтэй байдаг нь энэ

системийн ач холбогдол, түүнээс гарах мэдээллийн эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байна. Тухайлбал, Хилийн цэргийн удирдах газар, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын яамны статистик мэдээллийн төв, Эрүүл мэндийн даатгал, Улсын статистикийн газрын хүн амын хэлтэс, Эрдэм шинжилгээний байгууллагууд, Татварын ерөнхий газар, Гааль, банкны байгууллагууд, Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газар, Цагдаагийн байгууллагууд, аймаг, дүүргийн засаг даргын тамгын газар, манай байгууллагад харьяалагдах орон нутгийн албадууд гэх мэт ашиглах хүсэлтэй байна.

Гэвч ИБМУТ-ийн техник, тоног төхөөрөмжийн байдлаас сүлжээнд холбогдож чадахгүй, хөрөнгө мөнгөний асуудлаас шийдэгдэхгүй байсаар байна.

Бид мэдээллийн сүлжээг байгуулах, мэдээлэл харилцан солилцох ажлыг өөрсдийн хүчээр туршин байгуулах боломжтойг баталсан. Орон нутгийн албадыг ялангуяа эхний ээлжинд аймгуудыг ИБМУТ-тэй холбон мэдээллийн сүлжээ байгуулж чадвал өнөөдөр ИБМУТ-тэй төвлөрсөн журмаар мэдээллийг авч компьютерт оруулдаг ажил зогсож, мэдээг орон нутагт оруулдаг болох юм. Ингэснээр орон нутгийн албадууд хүн амынхаа мэдээллийн сантай болж, иргэд, албан байгууллагад үйлчлэх үйлчилгээг хөнгөн шуурхай болгон хөгжлийн шинэ хуудсыг нээх боломжтой болно.

Регистрийн системийг хөгжүүлсэн орнууд регистрийн мэдээллийн сан дээр тулгуурлан засаг захиргаа, яам тусгай газруудын мэдээллийн санг байгуулан компьютерийн сүлжээнд орох замаар мэдээллийн уялдаа холбоог өргөжүүлэн иргэдийн бүртгэлийн талаас бүрэн ажиглаж ихээхэн үр дүнд хүрч байна. Тухайлбал:

1. Австри, Чехсловак, Австри улсад эрүүл мэндийн даатгал, тэтгэвэр, тэтгэмжийн сан гэх мэтчилэн хүн амын нийгэм хангамжийн системүүдийг хүн амд олгосон РД-ын тусламжтайгаар регистртэй холбон ажиглаж нэлээд амжилтанд хүрч байна.

2. Эрүүл мэндийн салбарт регистрийн системийг сайн ашиглаж байгаа орнууд Норвег, Дани, Швед ордог.

3. Батлан хамгаалах, цагдаа, аюулаас хамгаалах чиглэлээр ашиглаж байгаа орнууд цөөнгүй. Түүнчлэн сонгуулийн ажилд ч ашиглаж байна.

4. ЕБС-д орох хүүхдийн жагсаалт, сурагчдын тоог гаргах, боловсрол эзэмшсэн байдлыг регистрээс гаргах ажлыг Унгар улс амжилттай хийж байна.


5. Зарим оронд ажиллах хүч, ажилгүйчүүдийн мэдээллийн системийг регистртэй холбон ашиглаж байна.

6. Албан татварын системд регистрийн мэдээлэл чухал ач холбогдолтой. Дани, Финлянд, Швед, Норвег татварыг регистрт тулгуурлан хийж байна.

7. Герман улс регистрийн системийг орон сууцны хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд ашиглаж байна.

8. Финлянд, Норвег, Швед, Япон, улсын регистр нь хүмүүсийн үе удам, өрхийн гишүүд, тэдгээрийн садан төрлийн холбоог 5 үеэр харуулж чадаж байна. Энэ бүхэн нь хүн амын автоматжуулсан регистрийн систе мийг хөгжүүлэн ашиглахын давуу талыг харуулж байна.


Манай улсын хувьд дээрх улс орнуудын нэг адил дэд сангуудыг байгуулан ашиглах бүрэн боломжтой бөгөөд ингэснээр илүү үр дүнд хүрэх нь мэдээж.



Хүн амын мэдээ тайланг гаргах ирээдүйн


ТОГТОЛЦОО

УЛСЫН ТӨВШИН




АЙМГИЙН ТҮВШИН

УЛСЫН ТӨВШИН




СҮМ, ХОРООНЫ

ТҮВШИН



Зураг-3

1980-аад онд хүн амын мэдээ тайланг гаргаж байсан тогтолцоо



Зураг-1

Хүн амын мэдээ тайланг гаргаж байгаа
өнөөгийн тогтолцоо

УЛСЫН ТӨВШИН

Иргэний бүртгэл
мэдээллийн
төв

Улсын
статистикийн
газар

А маягт

Монгол улсын
иргэний
бичиг, барим-
тын архив

АЙМГИЙН ТҮВШИН

Засаг даргын
тамгын газар,
цагдаагийн хэлт-
сийн паспортын
алба

Статистикийн
тайлан

Статистикийн
хэлтэс

Б маягт

Аймгийн
иргэний баримт
бичгийн архив

Сум, хорооны
ТҮВШИН

Статистикийн тай-
лан

ХААТР маягт

Гэрчилгээ

Бүртгэх дэвтэр
(бичиг барим-
тын архив)

Өргөдөл,
эмнэлгийн
тодорхойлолт

Ард иргэд

Зураг-2